

РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018.04.30

№..ХЭХ-18/1/1

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.11, Ремикон ХК-ийн 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2017 оны санхүүгийн болон үйл  
ажиллагааны тайланг батлах тухай

1. Ремикон ХК-ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 18/1/1 тоот дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

РЕМИКОН ХК  
ХУУЛБАР

РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018.04.30

№ ХЭХ-18/1/2

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.7, Ремикон ХК-ийн 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Нэр дэвшүүлэх хорооны хурлын шийдвэр, 2018 оны 04-р сарын 30-ны өдрийн Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүнээр томилох тухай

1. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр Х.Ганхуяг, Б.Батсайхан, И.Масатэру, Ч.Мөнгөнсүх, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан, Г.Батхуяг нарыг, хараат бус гишүүнээр Ө.Батбаяр, Н.Батгэрэл, Д.Алтанхуяг, С.Баянмөнх нарыг 2018 оны 4-р сарын 30-ны өдрөөс 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар тус тус томилсугай.

2. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зохих журмын дагуу цалин, хангамжийг бодож олгохыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

РЕМИКОН ХК  
ХУУЛБАР